



"ТАВАНТОЛГОЙ-ГАШУУНСУХАЙТ, ТАВАНТОЛГОЙ-ЗҮҮНБАЯН ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТАД ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГӨ, ҮР ДҮН" СЭДЭВТ ГҮЙЦЭТГЭЛ, НИЙЦЛИЙН АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖ, ТӨЛБӨРИЙН АКТ, АЛБАН ШААРДЛАГЫН ХЭРЭГЖИЛТЭД ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

2023.02.05

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Үндэсний аудитын газраас "Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүн"-д хийсэн хяналт шалгалт, зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн төлөвлөгөөний хэрэгжилтэд үнэлгээ хийж, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангах, цаашид гарсан алдаа дутагдлыг давтахгүй ажиллах, удирдлагыг холбогдох мэдээ, мэдээллээр хангах зорилгоор хяналт-шинжилгээний ажлыг гүйцэтгэлээ.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх нийтлэг журам"-ыг үндэслэв.

Гурав. Танилцуулга

3.1 Үндэсний аудитын газраас "Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг 2023 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 01/1486 дугаартай албан бичгээр тайланг хүлээн авч, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу "Зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г гүйцэтгэх захирлаар батлуулан Үндэсний аудитын газарт хүргүүлсэн болно.

Хүснэгт 1

Өгсөн зөвлөмж	Нийт арга хэмжээ	Үүнээс (хувиар)				Хувь
		100%	90%	70%	50	
Албан шаардлагын хүрээнд	6	4	2	-	-	96,6
Төлбөрийн актын хүрээнд	1	-	1	-	-	90,0
Зөвлөмжийн хүрээнд	9	6	1	2	-	92,2
Нийт	16	10	4	2	-	93,7

Дүгнэлт:

Тус төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн аудитын албан шаардлага 6, төлбөрийн акт 1, зөвлөмжийн хүрээнд 9, нийт 16 арга хэмжээний хэрэгжилтэд 2024 оны 02 дугаар сарын 05-ний өдрийн байдлаар үнэлгээ хийхэд нэгдсэн дүнгээр 93,7 хувьтай "Тодорхой үр дүнд хүрсэн" гэсэн үнэлгээтэй байна.